



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2017-12-15 № 18

МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,  
САНГИЙН САЙД  
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

Асуулга тавих тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 23.1-д заасны дагуу нийт иргэн, Улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримталж УИХ-ын тухай хуулийн 33.2-т заасны үндэслэн асуулга тавьж байна. Ингэхийн учир нь ГЕГ-ын удирдлагын зүгээс төрийн хууль, тогтоомжийг ноцтой зөрчих; төр нийгмийн ашиг сонирхолыг хохироох; татвараас зайлсхийж улсын төсвийн орлогыг хомсдуулах үйлдэл гаргах болсон тухай ард иргэд, аж ахуйн нэгжүүдээс гомдол, санал гарах болсонтой холбоотой.

Гаалийн Ерөнхий газрын дарга 2017 оны 06 дугаар сарын 30-ний өдөр А/162 тоот тушаал гаргаж “Татваргүй барааны дэлгүүр” ажиллуулах зөвшөөрөл олгохдоо хууль, журам зөрчсөн; сонгон шалгаруулалт явуулаагүй; энэхүү хууль бус үйл ажиллагааны улмаас 950 гаруй сая төгрөгийн татвар чөлөөлөгдөж улсын төсөвт хохирол учирсан тухай мэдээлэл ирсэн байна.


Мөн энэ оны 10 дугаар сард дээрх шийдвэрээ цуцалснаар бизнес эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн дотоод, гадаад үйл ажиллагаанд саатал, хохирол гарч төлбөр торгуулийн асуудал яригдаж эхэлжээ. Энэ байдал нь төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг төсөв хариуцан барагдуулдаг байсан буруу жишиг давтагдахад хүргэж болзошгүй байна.

Төр, нийгмийн ашиг сонирхлыг хохироосон хууль бус үйлдлийг таслан зогсоох; иргэд, аж ахуйн нэгжид учирсан хохирлыг барагдуулах нэрээр төсөвт нэмэлт ачаалал бий болохгүй байх; Улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх, бааз суурийг өргөтгөх, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн бодлогыг цэгцлэх, гаалийн байгууллагын нэр хүнд, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, төрийн тусгай албан хаагчдын хууль ёсны эрх, үүргийг баталгаажуулж, хууль дээдлэн, өндөр ёс суртахуунтай ажиллуулахад анхаарал хандуулан судалгаа дүгнэлт хийж, цаашид хэрхэн ажиллахаар төлөвлөж байгааг тань тодруулж хамтран ажиллах зорилгоор асуулга тавьж байна.

Асуулгын хариуг хуульд заасан хугацаанд ирүүлсний дараа хийсэн дүгнэлт, хийх ажлын цар хүрээ, ач холбогдлоос хамаарч УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, шаардлагатай асуудлаар УИХ-ын шийдвэрийн төсөл санаачилж хэлэлцүүлэх асуудлаа УИХ-ын тухай хуулийн 7.1.13-р заалт УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49-р зүйлд заасны дагуу шийдвэрлэх болно.

Таныг хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Ч.УЛААН

0000000031